



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/55

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 14.1.1, 15.3.5 дахь заалт, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батлан хамгаалах яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дэргэдэх техник, технологийн мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг батлагдсан өдрөөс үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Батлан хамгаалахын дэд сайд, яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дарга Б.Баярмагнайд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар /хурандаа С.Ганбямба/-т даалгасугай.

САЙД



Г.САЙХАНБАЯР

1321100151

Батлан хамгаалахын сайдын 2021 оны
03 дугаар сарын 16-ны өдрийн
А/Б дугаар тушаалын хавсралт

**БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН
МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журам нь Батлан хамгаалах яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дэргэдэх Техник, технологийн мэргэжлийн зөвлөл (цаашид “Зөвлөл” гэнэ)-ийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Зөвлөл нь зэвсэглэл, цэргийн техник, технологийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан, техник-эдийн засгийн үндэслэл, инженерийн зураг төсөл зэргийг хэлэлцэж, холбогдох хууль, дүрэм, судалгааны арга, аргачлал, стандарт, норм, нормативд нийцэж байгаа эсэх талаар хянан магадлах, мэргэжлийн үнэлэлт, дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөл⁵ мөн.

1.3. Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг Батлан хамгаалахын сайдын багцад тусган санхүүжүүлнэ.

1.4. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн санал болгосноор батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална⁶.

1.5. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Технологи дамжуулах тухай хууль, Инновацын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, батлан хамгаалах салбарт шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого, стратегийн зорилт, тэргүүлэх чиглэл, тэдгээрийг хэрэгжүүлэх хэтийн болон жилийн төлөвлөгөө, судалгаа шинжилгээний стандарт, норм, нормативыг удирдлага болгоно

Хоёр. Зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.2. Зөвлөл нь 9-11 гишүүнтэй байна.

2.3. Зөвлөлийн бүрэлдэхүүн нь Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, харьяа сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудын удирдах албан тушаалтан болон эрдэмтэд, залуу судлаачид, инженер, зөвлөх

⁵ Батлан хамгаалах яамны шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.4 заалт: Зөвлөл нь доорх салбар зөвлөлтэй байна.

- Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал, цэргийн ухааны салбар зөвлөл;

- Техник, технологи, инновацийн салбар зөвлөл; гэсэн бүтэцтэй байх бөгөөд салбар зөвлөл нь 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байна.

⁶ Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг. Яамны шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах

инженерүүдийн төлөөллөөс бүрдэх ба түүний 2/3 нь боловсролын доктор, түүнээс дээш эрдмийн зэрэгтэй байна.

2.4. Зөвлөлийн дарга нь зөвлөлийн үйл ажиллагааг удирдах, хурлаар хэлэлцүүлэх асуудлыг батлах, хурал даргалах, гишүүдийн ачааллыг тэнцвэртэй байлгах зохицуулалт хийх, тэднийг үүрэг, даалгавраар ханган ажиллах, зөвлөлийн шийдвэрийг удирдлагад танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулах, зөвлөлийн эрхлэх асуудлын хүрээнд бусад байгууллагатай хамтран ажиллах үүрэг хүлээнэ.

2.5. Зөвлөл орон тооны бус нарийн бичгийн даргатай байна. Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын шинжлэх ухаан, технологийн бодлогын ахлах мэргэжилтэн нь зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэнэ

2.6. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн үйл ажиллагааны тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих, тайланг зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх, зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангах, зөвлөлийн баримт бичгийг хөтлөх, удирдлагын болон бусад байгууллагад явуулсан, ирүүлсэн баримт бичгийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах үүрэгтэй.

Гурав. Зөвлөлийн эрх, үүрэг

3.1. Зөвлөл нь дараах эрх эдэлнэ:

3.1.1. Зөвлөл нь энэхүү журамд заасан асуудлаар холбогдох албан тушаалтны илтгэл, танилцуулгыг зөвлөлийн хурлаар хэлэлцэх;

3.1.2. Зөвлөлийн дарга нь зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөтгөх, зөвлөлийн ажиллах журамд өөрчлөлт оруулах саналаа БХЯ-ны ШУТЗ-ийн даргад танилцуулж, шийдвэрлүүлэх;

3.1.3. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой албан тушаалтнууд, цэргийн анги, байгууллагын төлөөллийг хуралд оролцуулах, хурлын бэлтгэл ажлын явцад шаардлагатай тодруулга, нэмэлт материалыг тэдгээрээс авах;

3.1.4. Зэвсэглэл, цэргийн техник, технологийн судалгаа боловсруулалт, туршилтын ажлын гүйцэтгэлтэй холбоотой санал, зөвлөмжийг БХЯ-ны ШУТЗ-д уламжлах.

3.2. Зөвлөл дараах үүрэг хүлээнэ:

3.2.1. Зөвлөл нь БХЯ-ны ШУТЗ-ийн төлөвлөгөөний дагуу тус зөвлөлөөс зэвсэглэл, цэргийн техник, технологийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан, судалгааны үр дүнд бий болсон инновацын бүтээгдэхүүн, түүний техник-эдийн засгийн үндэслэл, инженерийн зураг төсөл зэрэг нь холбогдох хууль, дүрэм, судалгааны арга, аргачлал, стандарт, норм, нормативд нийцэж байгаа эсэх талаар хянан магадлах, үнэлэлт, дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх асуудлаар өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх, биелэлтийн явц, үр дүнг тайлагнах, шаардлагатай санал, зөвлөмжийг хэлэлцүүлэх;

3.2.2. Зэвсэглэл, цэргийн техник, технологийн талаар холбогдох хууль эрх зүйн акт, бодлогын болон стандартын баримт бичиг, норм, нормативын асуудлаар саналаа яамны ШУТЗ-д уламжлах⁷;

3.2.3. Цэргийн зориулалттай болон нууцтай холбоотой зохиогчийн эрх, патент, шинэ бүтээл, барааны тэмдэг, ашигтай загварын гэрчилгээ авахад шаардлагатай болон зохиогчийн⁸ өөрийн санаачилгаар гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах талаар үнэлэлт, дүгнэлт, саналыг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмчийн газар, холбогдох бусад байгууллагад гаргаж өгөх;

3.2.4. Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний болон бусад байгууллагатай зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын хүрээнд хамтран ажиллах⁹;

3.2.5. Зэвсэглэл, цэргийн техник, технологийн хөтөлбөр, төсөл боловсруулалтыг хянан магадлах¹⁰;

3.2.6. Зөвлөлийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлсэн судалгаа боловсруулалт, туршилтын ажлын тайланг хэлэлцэж, үнэлэлт, дүгнэлт өгөх¹¹;

3.2.7. Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн судалгаа боловсруулалт, туршилт зохион бүтээх ажлын үр дүнг үйлдвэрлэл, цэргийн хэрэгт нэвтрүүлэх талаар зөвлөмж өгөх¹².

Дөрөв. Зөвлөлийн үйл ажиллагаа

4.1. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлийн хурал байна. Зөвлөлийн хурлын чөлөөт цагт өдөр тутмын үйл ажиллагааг нарийн бичгийн дарга зохион байгуулна.

4.2. Зөвлөлийн хурлыг улиралд 1-ээс доошгүй удаа хуралдуулна. Шаардлагатай үед зөвлөлийн даргын шийдвэрээр гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувийн ирцтэйгээр зөвлөлийн хурлыг зохион байгуулж болно. Инноваци, шилдэг бүтээлүүдийг хэлэлцэх болон тулгамдсан бусад асуудлаар БХЯ-ны ШУТЗ-ийн даргын шийдвэрээр зөвлөлийг мэргэжлийн хүмүүс, эрдэмтэн, судлаачдаар өргөтгөн хуралдуулж болно.

4.3. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын танилцуулга, үндэслэл болон шаардлагатай бусад материалыг хурал эхлэхээс ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд тараах ба зөвлөлийн дарга нь хэлэлцэх асуудлын онцлогийг харгалзан зөвлөлийн гишүүдээс мэргэжлийн шинжээчдийг томилон ажиллуулна.

⁷ Батлан хамгаалахын сайдын 2020 оны А/191 дугаар тушаал.

⁸ "Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай" хуулийн 3 дугаар зүйл 3.1.1. зохиогч" гэж өөрийн оюуны бүтээлч үйл ажиллагаагаар бүтээл туурвисан хувь хүнийг;

⁹ "Шинжлэх ухаан, технологийн тухай" хуулийн 9 дүгээр зүйл. 9.1.9.их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах;

¹⁰ Батлан хамгаалахын сайдын 2020 оны А/191 дугаар тушаал

¹¹ Шинжлэх ухаан, технологийн тухай" хуулийн 9 дүгээр зүйл. 9.1.5.хэрэгжүүлсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын тайланг хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгөх;

¹²Батлан хамгаалахын сайдын 2020 оны А/191 дугаар тушаал

4.4. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан зөвлөлийн гишүүн бус эрдэмтэд, мэргэжилтнүүдийн санал дүгнэлтийг сонсож болно.

4.5. Зөвлөл нь хэлэлцсэн асуудлаар үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргана. Зөвлөлийн үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг Батлан хамгаалах яамны шинжлэх ухаан, технологийн зөвлөл болон холбогдох бусад байгууллагад уламжилна.

4.6. Зөвлөлийн бүрэлдэхүүний ажилласан хөлс /урамшуулал/-ийг зөвлөлийн даргын уламжилснаар БХЯ-ны ШУТЗ-ийн даргын шийдвэрээр хагас жил тутамд олгоно.

Тав. Бусад

5.1. Зөвлөл нь Батлан хамгаалах яамны шинжлэх ухаан технологийн зөвлөлд ажлаа жил бүр тайлагнана.

5.2. Зөвлөлөөр үнэлэлт дүгнэлт гардуулахаар хандахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дарга тухай бүрт нь удирдамжаар батална.

5.3. Зөвлөлийн гишүүд хурлаар хэлэлцсэн асуудлууд болон судалгаа боловсруулалт, туршилт зохион бүтээх ажлын нууцлалыг чанд сахина.

**БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН
МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛ**